



БАРИЛГЫН АЖИЛД ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

2020 оны 04-р сарын 16-ны өдөр

№: АТТ-20
111-109/29

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг "Монголын төмөр зам" ТӨХК, түүнийг төлөөлж Инженер технологийн газрын дарга Д.Нямлхагва /цаашид захиалагч гэх/ "Гео зураглал" ХХК, түүнийг төлөөлж инженер Л.Сумхүү /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ нар Монгол Улсын хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зорилт нийтлэг үндэслэл

1.1. Захиалагчийн албан ёсны хүсэлт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгч, захиалагчийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.65 км төмөр замын ус зайлуулах хоолойн барилга угсралтын ажил /цаашид барилгын ажил гэх/-д зураг төсөл зохиогчийн хяналт тавих цогц ажил үйлчилгээ хийхтэй холбоотой талуулын хооронд үүсэх харилцаанд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тогтоож, зохицуулна.

1.2. Зохиогчийн хяналтыг Монгол Улсад мөрдөж байгаа Иргэний хууль, Барилгын тухай хууль, Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм, БНБД 11-04-99, хууль тогтоомжийн бусад актын хүрээнд хэрэгжүүлнэ.

1.3. Зохиогчийн хяналт нь эрх бүхий байгууллагуудаар зөвшилцөн баталгаажсан зураг төсөл, техникийн нөхцөлийг үндэс болгоно.

1.4. Зохиогчийн хяналт тавих явцад захиалагчийн санаачлагаар төсөлд зарим нэг өөрчлөлт оруулах, энэ өөрчлөлт нь хийцийн бат бэхийн тооцоог дахин хийх, архитектур төлөвлөлт, ерөнхий төлөвлөлт, инженерийн холболт, систем болон ажлын зурагт өөрчлөлт оруулах шаардлагагүй бол, энэ өөрчлөлтийг гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж болно.

1.5. Гүйцэтгэгч нь гэрээний хавсралт №1-д заасан хуваарийн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд барилгыг улсын комисст хүлээлгэн өгөхөд зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн дүгнэлт гаргана.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Захиалагчийн үүрэг

2.1.1. Гэрээний талуудын ажлын уялдааг хангахын тулд захиалагч өөрийн бүрэн эрхт төлөөлөгчийг албан ёсоор томилж гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

2.1.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчид барилгын талбай дээр ажиллах нөхцөл бололцоог хангах,

2.1.3. Зохиогчийн хяналт хийхэд зайлшгүй шаардагдах зураг төслийн болон материал, бүтээц, эдлэлийн чанар, стандарт, туршилт шинжилгээний холбогдолтой баримт бичгүүдийг бэлтгэсэн байх;

2.1.4. Гүйцэтгэгчээс тавьсан асуудал тухай бүрт нь хариу өгнө.

2.1.5. Барилга угсралтын ажил ажлын зургийн дагуу хийгдээгүй, зөрчил илэрсэн тохиолдолд Гүйцэтгэгчид энэ тухай бичгээр тухай бүрд нь мэдэгдэж, зохиогчийн хяналтын хуудас дээр тэмдэглэгдэнэ.

2.2. Захиалагчийн эрх

2.2.1. Энэхүү гэрээний хүрээнд Гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийн Гүйцэтгэгчээс шаардах;

2.2.2. Өөрийн нэрийн өмнөөс гүйцэтгэгчтэй байнга харилцах хүнийг томилон ажлуулах эрхтэй.

2.3. Гүйцэтгэгчийн үүрэг

2.3.1. Гүйцэтгэгч зураг төслийн ажилтай холбогдох дараах асуудлыг шалгаж шийднэ:

- а) Шаардлагатай тохиолдолд Барилга байгууламжид хэрэглэж буй материал, бүтээц, эдлэл, түүний чанар нь улсын стандарт, зураг төсөл, туршилт, лабораторийн шинжилгээний үр дүн паспортын үзүүлэлттэйгээ тохирч байгаа эсэх;
- б) Барилга байгууламжийг барих явцад гүйцэтгэсэн ба гүйцэтгэж байгаа ажил нь зурагт заагдсан төслийн шийдэл, ажлын баримт бичгүүдийн дагуу хийгдэж байгаа эсэх;
- в) Инженерийн байгууламж, технологийн ба тусгай зориулалтын тоног төхөөрөмж, барилгын бүтээцийн угсралтын ажил нь барилгын зохион байгуулалт, үйлдвэрлэлийн ажил гүйцэтгэх норм, дүрэм, үйлдвэрлэлийн технологийн дагуу хийгдэж байгаа эсэх;
- д) Барилга, байгууламжийн бат бэх, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг зөрчихгүй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр орон нутгийн материал, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн барилга барих хугацааг богиносгох төсөвт өртгийг хямдруулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх боломжийг судлан баталгаажсан зураг төсөлд зохиогчийн эрхийн хэмжээнд өөрчлөлт оруулахын зэрэгцээ зураг төсөлд алдаа илэрвэл тухай бүрт нь залруулах;
- е) Буурь хөрсний шинж чанар инженер геологийн судалгааны дүгнэлттэйгээ тохирч байгаа эсэх, барилга, байгууламжид гүйцэтгэлийн зураг, схем боловсруулах, байнгын ажиглалтын тэмдэгт (репер) байрлуулах ажил нь зохих дүрэм, заавар, зураг төслийн дагуу хийгдэж байгаа эсэх.

2.3.2. Гүйцэтгэгч нь барилгын ажлын журналд "Зохиогчийн хяналтын хуудас" гэсэн нэрээр дор дурдсан зүйлүүдийг тэмдэглэнэ:

- а) Илэрсэн зөрчил, гэмтэл, түүний шалтгаан, арилгах аргазам, засварлах хугацааг заах;
- б) Зохиогч нь хяналт хийж урьд өгөгдсөн үүргүүд, тэмдэглэгдсэн заалтуудыг хэрхэн биелүүлсэн, хугацаанд нь гүйцэтгэсэн эсэхийг шалгаж биелэлтийг дүгнэх;
- в) Илэрсэн зөрчил, гэмтлийг засаж арилгах талаар урьд өгсөн заалтыг цаг хугацаанд нь гүйцэтгээгүй буюу чанаргүй гүйцэтгэсэн байвал биелэлтийг хангуулах талаар дахин авсан арга хэмжээний тухай бичих.

2.3.3. Гүйцэтгэгч нь барилга дээр ажиллаж хяналт хийх тоо, хугацааг нарийвчлан тогтоосон хуваарийг захиалагчтай тохиролцон баталж, уг хуваарийн дагуу ажиллана. Энэхүү хуваарь нь гэрээний хавсралт болох бөгөөд салшгүй хэсэг байна.

2.3.4. Барилга-угсралтын явцад гарсан батлагдсан зураг төслийг зөрчсөн, өөрчлөгдөж байгаа барилгын норм дүрэм, техникийн нөхцөл болон барилгын ажлын технологийг

зөрчсөн дутагдал согог илрүүлэн тухай бүрт нь засаж залруулах талаар Захиалагч, барилгын ажил Гүйцэтгэгчид шаардлага тавина.

2.3.5. Батлагдсан зураг төсөлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсвэл захиалагч болон гүйцэтгэгч бусад байгууллагатай тохиролцох ажлыг гүйцэтгэх бөгөөд зураг төсөлд оруулсан өөрчлөлтийг "Зураг төслийн баримт бичигт өөрчлөлт оруулах заавар"-ын дагуу гүйцэтгэж барилгын гүйцэтгэгч, захиалагчид өгч архивын материалд хавсаргана.

2.3.6. Барилга угсралтын ажилд гарсан алдаа, зөрчлийн талаар тухай бүрт Захиалагч, Гүйцэтгэгчид мэдэгдэж уг зөрчлийг хэрхэн хэдий хугацаанд арилгах талаар саналаа албан ёсоор гаргана.

2.3.7. Захиалагчаас уг барилгад батлагдсан зураг төсөлд заагдсанаас өөр дэвшилтэт материал хийц, технологийн хэрэглэх талаар санал ирүүлвэл ирүүлсэн саналыг хүлээн авч дүгнэлт гаргана.

2.3.8. Зураг-төсөл, ажлын зураг захиалагчийн хүсэлтээр тайлбар хийх, зөвлөгөө өгөх, захиалагч болон барилга угсралтын ажил гүйцэтгэгч нарын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд мэргэжлийн дүгнэлт гаргаж ажиллана.

2.3.9. Барилга угсралтын ажилд ашиглалтад хүлээн авах ажилд оролцох, холбогдох бичиг баримтыг баталгаажуулна.

2.3.10. Барилга угсралтын ажлын өргөтгөл шинэчлэлтийн ажлын явцад захиалагч гүйцэтгэгч байгууллагаас зураг төсөл, техникийн шийдэлтэй холбогдуулан тавьсан санал хүсэлтэд нийцүүлэн шийдвэрлэх асуудлыг зохиогчийн хяналт хийх үед шуурхай шийдвэрлэж, гүйцэтгэлийн зураг хийх;

2.3.11. Захиалагч, Гүйцэтгэгчээс ирүүлсэн албан тодруулга авах хүсэлтийн дагуу энэхүү гэрээнд тусгагдаагүй дараах нэмэгдэл ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

а) Барилга угсралтын баталсан зураг төслөөс өөрчлөгдөх тохиолдолд зааварчилгаа өгөх;

б) Зохиогчийн хяналт тавьж байгаа багт өөр шаардлагатай мэргэжилтнүүдийг оролцуулах;

в) Барилга байгууламжийн зураг төсөл зохиох норм ба дүрэм, стандарт, техникийн нөхцөлд өөрчлөлт орсны шалтгаанаас батлагдсан зураг-төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хариуцан гүйцэтгэх;

г) Гал, байгалийн гамшиг, аваар ослын шалтгаанаар угсрагдсан бүтээц гэмтэл согог учирвал түүнийг засварлах талаар санал дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх;

2.4. Гүйцэтгэгчийн эрх

2.4.1. Гүйцэтгэгч гэрээний болон бусад хугацаанд барилгын талбайд ажлын зорилгоор нэвтрэх эрхтэй.

2.4.2. Гүйцэтгэгч нэмэлт хяналт, зарим хийцийн туршилт хийх, ажлын аль ч хэсгийн хэмжилт шалгалт хийх талаар барилга- угсралтын ажил гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

2.4.3. Барилга-угсралтын ажил зураг-төслийн баримт бичгийн дагуу хийгдээгүй, техникийн нөхцөл болон стандартыг зөрчсөн, чанар хангалтгүй байдал ажиглагдвал ажлыг түр зогсоон холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

2.4.4. Урьд хийгдсэн зохиогчийн хяналтын дүгнэлтэд заагдсан "алдаа зөрчлийг арилгаагүй нөхцөлд дараагийн шатны хяналт хийхээс татгалзаж, улсын хяналтын байгууллагад хандах;

2.4.5. Гүйцэтгэгч барилга-угсралтын ажилд хэрэглэгдэж байгаа хийц, эд анги, материал зэргийн техникийн баримт бичиг, сертификат зэрэгтэй танилцах, шалгах эрхтэй

2.4.6. Гүйцэтгэгч барилга-угсралтын ажилд ноцтой зөрчил гаргасан, чанарын доголдол гаргаж хохирол учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар холбогдох байгууллагад хандах эрхтэй;

2.4.7. Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ажлыг гуравдагч этгээдийг хөлслөн хэрэгжүүлж болно. Энэ нөхцөлд ажлын чанар, гарах зардлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

2.4.8. Гүйцэтгэгч нь барилгын гүйцэтгэгч захиалагчийн төлөөлөгчтэй хамтран барилгын норм ба дүрэм, бусад техникийн баримт бичгийн заалтад нийцүүлэн дараах асуудлыг шийдэх эрх эдэлнэ.

- a) Зам талбай, тохижилтын асуудлыг байгаль орчин, цаг уурын нөхцөлтэй уялдуулан шийдэх;
- b) Барилгын материал, технологийн тоног төхөөрөмж, машин механизмыг ижил төстэй, тохирох өөр материал тоног төхөөрөмж, машин механизмаар орлуулан солих;
- c) Зураг төсөвт илэрсэн алдааг засаж залруулах, барилга угсралтын ажлыг саадгүй явуулахтай холбогдсон техникийн асуудлыг шийдэх;
- d) Чанаргүй гүйцэтгэсэн угсралтын ажлыг засах талаар барилгын гүйцэтгэгч захиалагчийн боловсруулсан техникийн шийдлийг хянан шийдэх;
- e) Улсын стандарт, техникийн нөхцөл хангахгүй материал, эдлэл тоног төхөөрөмж хэрэглэхийг хориглох.

Гурав. Ажил гүйцэтгэх хугацаа, үр дүнг хүлээлгэн өгөх,

3.1. Ажил гүйцэтгэх үе шат, хугацааг Захиалагчийн Гүйцэтгэгчтэй байгуулсан барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй уялдуулан харилцан тохиролцож гэрээнд хавсаргана.

3.2. Гүйцэтгэгч зохиогчийн үе шатны хяналт тавьсан тухай баримт бичгийг тухай бүрт бүрдүүлэн захиалагчид нэг хувийг өгнө.

3.3. Гүйцэтгэгч Захиалагч болон барилга угсралтын ажил гүйцэтгэгчийн гэрээний 3.2-т заасан баримт бичигтэй холбоотой гаргасан саналыг 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

3.4. Захиалагч зохиогчийн хяналт хийлгэх мэдэгдлийг Гүйцэтгэгчид цахим эсхүл албан бичгээр 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

Дцөрөв. Ажлын үнэлгээ, төлбөр тооцоо



4.1. Зохиогчийн хяналтын зардал “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019”-ийн 5.4.5-д заасан захиалагчийн хяналтын зардалд багтсан болно.

4.2. Ажлын хөлс болох 80,000,000 /наян сая төгрөг/-ийг тухайн барилгын угсралтын ажлын захиалагчийн хяналтын зардлаас хавсралт №1-д заасан хуваарийн дагуу санхүүжүүлнэ.

4.3. Захиалагч нь гэрээний нийт үнийн дүнгийн 20 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний урьдчилгаа төлбөр олгох бөгөөд урьдчилгаа төлбөрийг явцын болон эцсийн санхүүжилт тус бүрээс ижил хувиар суутгана.

4.4. Явц дундын 70 хувийн санхүүжилтийг 2 сар тутам ажлын гүйцэтгэлийн актыг үндэслэн дүгнэж олгоно.

4.5. Үлдэгдэл 10 хувийн санхүүжилтийг барилга угсралтын ажил бүрэн дуусч, техникийн комисс хүлээн авсны дараа олгоно.

4.6. Захиалагч санхүүжилтийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор түүний Толомт банк дахь 1601375103 тоот дансанд шилжүүлнэ.

Тав. Ажлын үр дүнг ашиглах, зохиогчийн эрхийг хамгаалах

5.1. Гэрээний дагуу төсөлд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд баримт бичиг нь Захиалагчийн мэдэлд байж тэдгээрийг өөрийн үзэмжээр, мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд, захиран зарцуулах эрхтэй.

5.2. Гэрээний дагуу Гүйцэтгэгчээс боловсруулсан бүх баримт бичгийг, Захиалагч - гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхгүй бөгөөд мөн түүний доторх мэдээллийг Гүйцэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр задлах эрхгүй. Гэхдээ төрийн байгууллагуудын шаардлагын дагуу дээрх мэдээллийг холбогдох газруудад өгөх нь дээрх заалтад хамаарахгүй болно.

5.3. Гүйцэтгэгч нь төслийн баримт бичгийн зохиогчийн эрхийг эдэлж, байгаагийн хувьд, уг баримт бичгийг зохиосон ба боловсруулсны үнэ хөлс, төлөгдсөнийг үл харгалзан зураг, техникийн нөхцөл, бусад баримт бичгийг ашиглах эрхтэй. Харин энэхүү гэрээний дагуу боловсруулсан нэмэгдэл төсөл, баримт бичгийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхгүй байна.

5.4. Гүйцэтгэгч захиалагчаас ирүүлсэн мэдээллийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс өөр зорилгоор ашиглахгүй.

Зургаа. Талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх

6.1. Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг сар тутам хамтран дүгнэнэ.

6.2. Гэрээний талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ дутуу биелүүлснээс үүссэн хохирлыг бүрэн хариуцаж, хохирлыг барагдуулна.

6.3. Гүйцэтгэгч дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хариуцлага хүлээнэ.

а. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй, чанарын доголдол гаргасан, хугацаа хоцруулсан бол;

б. Зураг төсөлд оруулах өөрчлөлтийг чанартай хийгээгүй, барилгын явц илэрсэн доголдлыг арилгах талаар зураг төслийн болон бусад техникийн баримт бичигт тусгаагүй бол;

6.4. Гүйцэтгэгчийн боловсруулсан зураг төсөлд оруулсан нэмэлт өөрчлөлт нь шаардлага хангаагүй бол захиалагчийн шаардлагын дагуу уг ажлыг өөрийн зардлаар нөхөн гүйцэтгэх ба гүйцэтгэгч гарсан хохирлыг хариуцна.

6.5. Гүйцэтгэгчийн буруугаар зураг төсөлд тусгагдсан үзүүлэлтийг барилгын ажил дуусахад бүрэн хангуулаагүй, мөн эдгээр хангагдаагүй үзүүлэлт нь хүний эрүүл мэнд, орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэх бол, гүйцэтгэгч хариуцлага хүлээж, хохирлыг барагдуулна.

6.6. Гүйцэтгэгчийн ажлын алдаанаас болж барилгын ажилд аваар осол, эвдрэл гэмтэл гарвал түүнээс учрах хохирлыг хариуцна.

6.7. Гэрээгээр авсан үүргээ хугацаанд биелүүлээгүй бол хугацаа хэтэрсэн, эсхүл гэрээний үүргээ тасалдуулсан хоног тутамд хийгдвэл зохих ажлын үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх алдангийг захиалагчид төлнө.

6.8. Захиалагч, барилгын гүйцэтгэгчид, зохиогчийн хяналт тавигчаас тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Уг шаардлагыг хугацаагаар нь биелүүлээгүйгээс гарах хохирлыг захиалагч, гүйцэтгэгч нарын хэн буруутай нь хариуцна.

6.9. Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэсэн актыг үндэслэлгүйгээр хүлээн авахгүй болон уг актын дагуу төлбөл зохих ажлын хөлсний төлбөрийг төлөлгүй хугацаа хэтрүүлбэл, хэтэрсэн хоног тутамд 0,5%-ийн алданги төлнө.

6.9. Гэрээний талуудаас үл хамаарах гэнэтийн шалтгаанаар барилга угсралтын ажил бүрэн болон бүрэн бус зогсох, хугацаа сунгагдвал, талууд хариуцлага хүлээхгүй.

6.10. Талуудаас үл хамаарах, давтагдашгүй хүчин зүйлс (байгалийн гамшиг, гал усны аюул, эдийн засгийн хямрал, улс төрийн байдал, Монгол Улсын эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийн улмаас төслийг үргэлжлүүлэх боломжгүй болох, санхүүжилт зогсох зэрэг зэрэг)- ийн улмаас талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрвэл гэрээнд заасан хариуцлагаас чөлөөлөгдөнө.

6.11. Талуудын хооронд үүссэн гомдол нэхэмжлэл маргаантай асуудлыг харилцан хүндэтгэх, хамтын ажиллагааны үзэл санааг баримтлан хэлэлцээрийн замаар шийдвэрлэх бөгөөд, маргааныг эв эеээр шийдвэрлэж чадахгүй нөхцөлд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээний хүчинтэй болох, өөрчлөлт оруулах, цуцлах үндэслэл

7.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн барилга угсралтын ажил дуусч, улсын комисст хүлээлгэн өгөх хүртэл хүчинтэй байна.

7.2. Гэрээнд өөрчлөлт, нэмэлт оруулахыг зөвхөн гэрээний талуудын зөвшилцлөөр хийгдэх бөгөөд талуудын эрх бүхий хүмүүсийн гарын үсгээр баталгаажин, үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

7.3. Энэхүү гэрээ талуудын харилцан тохирсон баримт бичгээр цуцалж болно.

7.4. Захиалагч дараах нөхцөлд өөрийн санаачлагаар нэг талаас цуцлах эрхтэй.

а. Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд гэрээгээр хүлээсэн үүрэгт ажлаа гүйцэтгэхгүй байх, эсвэл ажлын явц нь гэрээт үүргээ хугацаанд нь биелүүлэх боломжгүй болох нь тодорхой болсон;

б. Ажлын явцад, Гүйцэтгэгчийн ажлын чанар нь шаардлага хангахгүй нь тодорхой харагдаж байгаа бол (зураг төслийн болон бусад техникийн баримт бичиг нь шаардлага хангахгүй);

в. Гэрээний нөхцөлийг биелүүлэхгүй байх, эсвэл гарсан зөрчил нь засаж арилгахад хүнд, захиалагчийн зүгээс илрүүлсэн зөрчлийг бодит хугацаанд арилгаж чадаагүй бол;

г. Зөвлөх үндэслэлгүйгээр ажлын хөлсөө нэмэгдүүлсэн;

д. Барилгын ажлыг зогсоовол;

е. Гүйцэтгэгчийн энэ төрлийн ажил гүйцэтгэх зөвшөөрлийн лиценз цуцлагдвал;

7.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд өөрийн санаачлагаар нэг талаас гэрээг цуцлах эрхийг эдэлнэ.

а. Захиалагч хийсэн ажлын хөлсийг хугацаандаа төлөхгүй удаашруулах, эсвэл татгалзвал;

б. Гүйцэтгэгчийн зүгээс захиалагчийн гаргаж өгсөн мэдээлэл, материал зэрэг нь ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эсвэл шаардлага хангахгүй, талаар мэдэгдсээр байтал арга хэмжээ аваагүй тэр нь тухайн ажлыг хугацаанд нь дуусгах боломжгүй нөхцөлийг бүрдүүлсэн;

7.8. Аль нэг талаас өөрийн санаачлагаар гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө тал 14 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ. Уг мэдэгдлийн талаар 7 хоногийн дотор хариу ирэхгүй бол дахин хоёр дахь мэдэгдлийг явуулна. Энэхүү давтан мэдэгдлийг авсан тал мэдэгдэл авснаас хойш 7 хоногийн дотор хариу ирүүлэхгүй бол санаачлагч тал гэрээг цуцалж, ажлаа зогсооно.

7.9. Хэрэв захиалагч барилга-угсралтын ажлаа бүр мөсөн зогсоохоор шийдвэрлэвэл гэрээ цуцлах саналыг Гүйцэтгэгчид 14 хоногийн өмнө мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Найм. Бусад заалт

8.1. Энэхүү гэрээ хоёр хувь үйлдсэн ба хувиуд адил хүчинтэй.

8.2. Нэмэлт, гэрээ, оруулсан өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийгдэж талуудын эрх бүхий хүмүүсийн гарын үсэг, байгууллагуудын тамга, тэмдгээр баталгаажсан байна.

8.3. Гэрээний Хавсралт:

1-р хавсралт: Ажил гүйцэтгэх хуваарь, санхүүжилтийн хувь хэмжээ;

2-р хавсралт: Зохиогчийн хяналтын ажлын бүтэц, бүрэлдэхүүн;

Эдгээр нь уг гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээтэйгээ адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“ГЕО ЗУРАГЛАЛ” ХХК-ийн инженер



Л.СУМХҮҮ

Захиалагчийн төлөөлж:

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ийн
Инженер технологийн газрын дарга

 Д.НЯМЛХАГВА



Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414,6 км төмөр замын төслийн
Төмөрбетон хоолойн ажилд Зохиогчийн хяналтын ажил
гүйцэтгэх тухай дугаар гэрээний хавсралт №1



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУВААРЬ, САНХҮҮЖИЛТИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

| № | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Барилга угсралтын ажлын гүйцэтгэл | 10% | 20% | 40% | 60% | 80% | 100% |
| Гүйцэтгэгчийн ажиллах хоног | 5-7 хоног | 5-7 хоног | 5-7 хоног | 5-7 хоног | 5-7 хоног | 5-7 хоног |
| Санхүүжилтийн хувь хэмжээ /гэрээний нийт үнийн дүнгээс/ | 15 % | 15 % | 15 % | 15 % | 15 % | 15 % |

Тайлбар:

1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг угсралт хийгдсэн хоолойн тоо хэмжээнээс хувилан тооцно.



Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414,6 км төмөр замын төслийн
Төмөрбетон хоолойн ажилд Зохиогчийн хяналтын ажил
гүйцэтгэх тухай дугаар гэрээний хавсралт №2



“Гео зураглал” ХХК-ийн зохиогчийн хяналт тавих ажлын бүтэц, бүрэлдэхүүн:

| № | Нэрс | Мэргэжил | Утас |
|---|-------------|----------------------|----------|
| 1 | Л. Сумхүү | Гүүр хоолойн инженер | 99066152 |
| 2 | И.Отгонбаяр | Гүүр хоолойн инженер | 90098282 |

